

“ЦАГААН ТҮҮХ”-ИЙН НЭГЭН ШИНЭ
ЭХЭЭС ҮҮДСЭН СУДАЛГАА

Ш. Чоймаа*

Монгол хэл бичгээр бидэнд уламжилсан нэлээд эртний үед хамаарах монгол сурвалж бичгийн дотор “Цагаан түүх” зохих байрыг эзэлдэг, монголч эрдэмтэн хэн бээр мэддэг зохиол билээ. “Цагаан түүх”-ийн судалгаа нь, бидний мэдэж байгаагаар, 1936 онд Жамсрангийн Цэвээн (Ц.Ж.Жамцарано)-ий “XVII зууны монголын түүхэн сурвалжууд” (Монгольские летописи XVIII века) хэмээх бүтээлээс эхэлжээ. Түүнээс хойш, гадаад дотоодын олон эрдэмтэн судлаач энэ зохиолыг судалжээ. Монголын түүх, хууль цаазын зохиолд дурдсан болон тухайлсан өгүүлүүдийг эс оролцуулан, зөвхөн нэг сэдэвт зохиолыг дурдвал:

1. Ш.Нацагдорж “Цагаан түүх”-ийн тухай, УБ, 1956
2. Клаус Сагастер (Герман) “Цагаан түүх” (Die weisse geschichte) 1976 Wiesbaden
3. Лиү Жин Со “Арван буянт номын цагаан түүх” 1981, Хөх хот
4. С.Жалан-Аажав “Арван буянт номын цагаан түүхийн тухай” УБ 1998
5. Ц.П. Ванчикова “Цагаан түүх-XIII-XVI зууны Монголын түүх-хууль эрх зүйн сурвалж бичиг” (ᠰᠠᠭᠠᠨ teiuke - “Белая история” монгольский историко - правовой памятник XIII-XVI вв) Улан-Үдэ 2001.
6. Б.Баярсайхан “Монгол улсын арван буянт номын цагаан түүх” УБ 2002
7. “Арван буян номын цагаан түүх” хөрвүүлж, тайлбарласан Ш.Чоймаа, Р.Төрдалай “Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал” II боть, УБ 2006.

Өдгөө бидэнд уламжилсан “Цагаан түүх”-ийн эх хувилбарууд гэвэл:

I. Санкт - Петербургийн дорнодахины номын санд байгаа 3 эх

1. “F237” хэмээсэн шифртэй эх. “arban buyan-tu nom-un ᠰᠠᠭᠠᠨ teiuke neretü sudur”(Үүнийг 1910 онд Жамсрангийн Цэвээн бээр Ордосын Эзэн Хорооноос хуулж авчээ. Түүний тэмдэглэл бий.)
2. “Ms.G 92” шифртэй эх “mongyol-un arban buyan-tu nom-un ᠰᠠᠭᠠᠨ teiuke neretü biᠰig” (Монгол улсын судар бичгийн хүрээлэнгээс Жамсрангийн Цэвээнд 1937 онд өгсөн хуулбар эх)
3. “G 91” шифртэй эх. “erten-ü boydas-un bayiyuluysan dörben yeke törü-yin arban

*Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл, соёлын сургууль

buyantu nom-un čayan teüke neretü” Гадна хавтас дээр нь “dörben törü-yin arban buyantu nom-un čayan teüke” хэмээн бичсэн ажээ. (Монгол улсын шинжлэх ухааны хүрээлэнгээс Жамсрангийн Цэвээн 1937 онд аваачсан хуулбар эх)

II. Монгол улсын Үндэсний номын санд байгаа эх бичгүүд

1. “294, ЗД 602” шифртэй “mongyol ulus-un arban buyan-tu nom-un čayan teüke neretü sudur orusiba” (Энэ эхийг 2002 онд Б.Баярсайхан 2006 онд “Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал” 30 ботийн хоёрдугаарт тус тус эх бичиг болон хөрвүүлэг, тайлбарын хамт хэвлүүлсэн.)
2. “294, 352, Д-602” шифртэй “dörben törü-yin arban buyan-tu nom-un čayan teüke orusiba” (Энэ эхийн латин галигийг 2001 онд Ц.П.Вачикова “čayan teüke” (Цагаан түүх) номдоо бусад эхтэй харьцуулан латин галигийг нь хэвлүүлсэн)
3. Гандан хийдийн номын санд байсан эх бичиг “erten-ü boyda sayid-un bayiyuluysan dörben yeke törü-yin yosun jüil-i uqayulqu-yin onisun arban buyan-tu nom-un čayan teüke neretü sudur” (Энэ эхийн гэрэл зураг болон латин галигийг 2001 онд Ц.П.Ванчикова “čayan teüke” (Цагаан түүх) номдоо хэвлүүлсэн.)

III. БНХАУ-ын Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд буй 8 эх бичиг

1. “arban buyan-tu nom-un čayan tegüke neretü sudur-un ekin orusiba” (1958 онд Их Зуу аймгийн Чүшин хошууны Ванчигравданы гэрээс олж авчээ.)
2. “qoyar yosun-u dörben törü-yin arban buyan-tu nom-un čayan teüke” (Агуулгын хувьд дээрхтэй адил боловч хожмын хуулбар ажээ.)
3. Нэртэй хуудас нь үгүй бөгөөд агуулгын хувьд өмнөх 2 эхтэй ойр боловч, муу хуулбар хэмээн Лиү Жин Со тодорхойлжээ.
4. “erten-u boydas-un bayiyuluysan dörben yeke törü-yin kičiyengküi arban buyan-tu nom-un čayan teüke neretü sudur orusiba, yeke nom-un čayan teüke neretü sudur orusiba, yeke nom-un čayan teüke basaču bui.” (гээж орхигдуулсан зүйл ихтэй муухан хуулбар бөгөөд 1956 онд олж авчээ.)

5, 6 дахь эх нь дээр 4-рт дурдсан эхийн хуулбар ажээ. Нэр нь ч адил буй. 7 дахь нь “arban buyantu nom-un čayan teüke terigüten yurban jüil-i tegüsekebe” хэмээн гадар нүүрт бичсэн эх. Лиү Жин Со-гийн судалснаар 5, 6 дугаартай адил 4 дүгээрийн хувилбар ажээ.


4, 5, 7 дугаар эхийн хамт “Хөх түүхийн хураангуй”, “Сувд эрихний шастир” хэмээх 2 зохиол байсан болохыг Лиү Жин Со магадлажээ.

8 дугаар эх нь Өвөр Монголын номын санд хадгалж байгаа “arban buyan-tu nom-un čayan teüke” хэмээх эхийг дахин хуулсан эх. 3 дугаар эхтэй агуулга нь таардаг хувилбар ажээ.

Дээр дурдсан эхүүдийн агуулга, үг үсгийн зөрөөг судлаачдын хэвлүүлсэн эхээс бид тодорхой мэдэж буй. Ялангуяа, 2001 онд Ц.П.Ванчиковагийн хэвлүүлсэн “Цагаан түүх” номд гол найман эх бичгийн латин галигийг хийж, харгуулан харьцуулж хэвлүүлсэн нь судлаач нарт нэн чухал хэрэглэгдэхүүн болж буй.

Миний бие энэ жил Монгол улсаас “nom-un čayan teüke čedig neretü sudur orusiba” хэмээсэн судар олсон болно. Уг ном ихэд элэгдэж хуучирсан, бас төгсгөлийн хуудас дутуу байх боловч, судалгааны үнэ цэнэтэй “Цагаан түүх”-ийн нэгэн хуучин эхийн хувилбар байна. Судрын эхэнд “Хураангуй алтан товч”-оос нэлээд хэсгийг авч, монголын хаад ноёд, овог аймгийн

гарал угийг тоочсон хэсэг байна. Монголын гол уг удам буюу Алтан ургийн хаадыг тоочин бичсээр ... tümen jasaγ-tu qaγan, sečen qaγan, mangγus qaγan, qutuγtu qaγan, erke qongγur, abunai čing wang, burani čin wang” (Түмэн засагт хаан, Сэцэн хаан[Буянт сэцэн хан], Мангус хаан, Хутагт хаан[Лигдэн хутагт хаан], Эрх хонгор, Абунай чин ван, Бурани чин ван) гээд зогсчээ. Түүхэнд тодорхой зүйл бол Абунайг гянданд хоригдож байхад, түүний хүү Бурни, Лувсан нар Манж Чин улсыг эсэргүүцэн хөдөлж, улмаар 1675 онд алагдсан түүхтэй. Энэ номын эхэн хэсэгт дурдсан ноёдын уг удам бичсэн байдал нь 17-р зууны сүүлч орчим хүрээд зогссоныг үзвэл, энэ хуулбар эх нь 17-р зууны эцэс орчимд бичигджээ хэмээн таамаглаж болох буй. Гэвч нарийвчлан судлах болно. Бидний сонирхож буй “Цагаан түүх” нь уг судрын 4-р хуудасны “а” талын сүүл хэсгээс эхэлж буй. Энэхүү судар нь “7,5 см х 49 см” хэмжээтэй 11 хуудас зохиол бөгөөд эцсийн хуудас нь дутуу юм. Энэ эх нь Ц.П.Ванчиковагийн судалсан Монгол улсын Гандан хийдийн номын санд байсан судартай агуулга таарах бөгөөд энэ хоёр эх нэг гаралтай, бас эртний эхийн хувилбар болох нь тодорхой байна.



Миний бие энэхүү шинээр олсон эхээ судалж байгаа бөгөөд зарим шинэ сэдэл санаа, олсон тодруулгаа өгүүлье.

1. Сурвалж бичгийн судлалд аль нэг хувилбар олдох нь нэн чухал. Хэдийгээр алдаа мадагтай, элж хуучирсан, дам хуулбар байсан ч гэсэн бусад эхийн үг, үсэг, өгүүлбэрийг зөвөөр тайлж уншихад, нэн чухал бөгөөд нэгэн зохиолын эхийг судлахад бусад бүх хувилбарыг үг үсгээр нь харгуулан үзэх нь эрхэм билээ. Шинээр олдсон эхээс “Цагаан түүх”-ийн зарим хэсгийг тодруулъя.

6в талд



“**silün malaq-a** degel büse-е yodusun-i emüsсü, **sil** tabčang-un degere qalturil түsil үгеи yаруyад, **narbai orγun-i** usqal jibqulang-iyar jasaju yirtinčü-yin törü engke **čing** qoyar tusburi yabuγul-un čidabasu, degedü күндү törü-tü qayan kemeyü ...” гэж буй. (*Шилийн малгай, дээл, бүс, гутлыг өмсч, шил тавцангийн дээр халтирал түшилгүй гараад, нармай оргоныг(нийт албад иргэнийг) усгал жавхлангаар засаж, ертөнцийн төр энх, чин хоёр тус бүр явуулан чадваас, дээд хүнд төрт хаан хэмээюү...*)

“Цагаан түүх”-ийн энэ хэсэг бүх л хувилбарт байдаг боловч, “silün[=sil-ün]”, “sil” болон “čing” хэмээх үгс нь өөр өөр бичлэгтэй байх тул судлаачид энэ хэсгийг бүрэн ойлгож ядаж, эргэлзсэн тайлбар, ташаа тайлбар хийж иржээ.

К. Sagaster (1976)

“**salun malayai** debel büse yodusun-i emüsсü, **sil-ün**(A sal-un) tabčang-un degere qalturil түsil үгеи yаруyад, **narmai yeke ulus-i** usqal jibqulang-iyar jasaju yirtinčü-yin törö engke **kilbar** qoyar yosu-yi qolil үгеи tus бүри ken yabuγul-un čidabasu күндү degedü törü-yin qayan kemeyü ...”¹

Лiu Жин Со (1980)

“**sal malayai**, degel, büse, yodusun-i ken emüsсü, **sal-un** tabčang-un degere qalturil түsil үгеи yаруyад, **narmai yeke ulus-i** usqal jibqulang-iyar jasaju, yirtinčü-yin törü engke **kilbar** qoyar yosun-i qolil үгеи tus бүри čida-basu күндү degedü törü-tü qayan kemeyü ...”²

Ц.П. Ванчикова (2001) Гандан хийдэд байсан эх

“**sal-un malaq-a** büse degelk yutusun emüsсü: **sil** tabčang-un deger-e qalturil түsil үгеи yаруyад, **narbai irgen urγu-i** usqal jibqulang-i=iyar jasaju: yirtinčü-yin törü engke **jin-e** qoyar-i tusburi yabuγul-un čidabasu: үнен degedü күндү törü-tü qayan kemeyü ...”³

Дээрх гол эхүүд, түүний судалгааны галигт байгаа тодруулсан үгсийг харьцуулан үзэхэд, шинээр олсон болон Гандан хийдэд байсан эх хоёр нь эртнийх болох нь мэдэгдэнэ. Тухайлбал, “narbai orγun”, “narbai irgen orγu(n)-i (Гандангийн эхэд)”, “malaq-a” хэмээснийг бусад эхэд “narmai yeke ulus”, “malayai” хэмээсэн байх жишээтэй. Энэ хэсгийг толилуулахын учир бол агуулгыг бүрэн тодлох түлхүүр үгсийн тухайд юм. “sal”(сал) буюу “sal-un”(салын) бус “sil”(шил), “sil-ün”(шилийн) байх ёстой нь шинэ эхээс тодорхой бөгөөд утга, учирзүйгээр бодсон ч, шил тавцан дээр шил өмсгөлтэй хүн тогтоход нэн бэрх, маш хянуур нямба хөдлөх хэрэгтэй нь гарцаагүй бөгөөд улсыг засахдаа тийм нарийн хянамгай хандах ёстойг үлгэрлэн өгүүлсэн ажээ. Нөгөө нэг тодорч байгаа зүйл бол “čing” хэмээх үгийг бусад эхэд “kilbar”(хялбар) гэж гардаг бөгөөд судлаачид эргэлзсэн байдаг. Академич Ш.Бира бичихдээ “Жад сумын үзүүрийн “gilber”(гилбэр)-ээс утга шилжиж, “хүч хэрэглэх”(насилие), “цэргийн хүч”(военная сила) гэсэн утгатай болжээ”⁴ гэсэн бол Ц.П. Ванчикова “jigi”(плач, рыдание-уйлаан орилоон, цурхиран уйлах) гэсэн утгатай эртний түрэг үгээс гаралтай үг байж магадгүй гээд, оросоор орчуулахдаа “дарангуйлах” гэсэн утгатай үгээр орчуулжээ. Гэхдээ, Гандангийн эхэд “čing” хэмээх үгийг “jini” гэж уншиж болохоор бичсэн тул ийм дүгнэлт

¹ Klaus Sagaster “die weisse geschichte” Otto Harrassowitz, wiesbaden, 1976., 88-р тал.

² Liu jin soo “arban buyantu nom-un čayan teüke” köke qota, 1981., 80-р тал.

³ Ц.П. Ванчикова “čayan teüke - “Белая история” монгольский историко - правовой памятник XIII-XVI вв” Улан-Үдэ, 2001., 42-р тал.

⁴ Ш.Бира “Монгольская историография(XIII-XVII вв)” 287-р тал.

хийхэд хүрчээ. К.Сагастер “leichtigkeit”(хялбар) гэж орчуулсан⁵. Утгын хувьд “хялбар” гэдэг үг үл тохирох бөгөөд шинэ эхийн “cing”(чин) гэдэг үг харин таарах юм. “cing” хэмээх үг, сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудад олон тохиолдох бөгөөд “МНТ”-нд ч тохиолдоно. Жишээлбэл, 1335 оны Chang Ying-jüi-гийн хөшөөний бичээст “... tegüs cing ayali aburitu bolju engke sayin çay-tur uciraju ...”⁶(Төгс чин ааль авирт болж, энх сайн цагт учирч) хэмээн байх ба 1338 оны Hindü вангийн хөшөөний бичээст “cing jorig[-iyaran] beyeben ariγun-a saqju sayun ajiγai”⁷(Чин зоригороо биеэ ариунаа сахиж суун ажээ) гэж буй. Мөн “hua-I-ih-yü”(Хуа-и-и-юу) толь бичгийн зүйлд “altan cilawun metü cing ci’iraq ese bol=u=wasu. tenggiri-yin jorig-i daqa=n ker čida=qu”⁸ (Алтан чулуу мэт чин чийрэг эс болбоос, тэнгэрийн зоригийг даан хэр чадах) хэмээн гарч буй. “cing čigiray” хэмээсний хятад орчуулга нь “chéng shi” (үнэнч, шударга) хэмээсэн нь оносон орчуулга бус бололтой. Харин “batu čigiray”(бат чийрэг) хэмээсэн утгаар “cing ci’iraq” хэмээх үгийг хэрэглэсэн нь тодорхой байна.

Цавчаал боомтын дөрвөлжин үсгийн бичээст:

“Bodhisivid-un altan jorig čiq-un tula-da eldeb keregü:d tegüs бүтү(‘)e:n” čabča’a:l dotor-a e’ü:ri urtu-da bay:qu-yin čila’u:n gürüs-iyar ene suburyan-i ülü uda’u:lun tegüs бүтү’e:beyi.”⁹ (Бодисатвагийн алтан зориг **чингийн** тулд элдэв хэргүүд төгс бүтээн Цавчаал дотор үүр уртад байхын чулуун гүрсээр энэ суваргыг үл удуулан төгс бүтээвэй.) хэмээн гарах бөгөөд энд чин хэмээх үгийг мөнхүү “бат” гэсэн утгаар хэрэглэжээ.

Сажа бандид Гунгаажалцаны “Субашид”-ын Соном Гарагийн орчуулга(13-14 зуун)-д тохиолдох жишээг онцлон авч, төвд эхтэй нь харгуулан үзвэл, төвд эхдээ “brtan”(བརྟན) хэмээснийг “cing boluyu” хэмээн орчуулжээ¹⁰. “Субашид”-ын 4-р бүлгийн төгсгөлийн тэр бадгийг бусад орчуулгатай харьцуулан үзье.

Төвд эх

ལྷན་པོ་ཅིས་ཀྱང་མི་སྐྱེ་བ།

lhun po cis kyang mi sgul ba

དེ་བཞིན་བདག་ཉིད་ཆེན་པོ་བརྟན།

de bzhin bdag nyid chen po brtan

ཤིང་བལ་རྒྱུང་ལུས་གཡོ་བ་ལྟར།

shing bal chung ngus gyo ba ltar

དམན་པའི་སྤོང་བ་འགྱུར་ལོག་ཆེ།

dman pa'i spyod pa 'gyur ldog che

Соном-Гарагийн орчуулга (XIII-XIV зуун)

Sümür ayula ken-e ber ülü ködelgedemüi

Tegünčilen boyda sayid cing boluyu

Modun-u ungyaril ücügüken-e ködelgedekü metü

Mayun-u aburi körbemdegü boluyu.

⁵ Klaus Sagaster “die weisse geschichte” Otto Harrassowitz, wiesbaden, 1976., 118-р тал.

⁶ D.Tumurtogoo “Mongolian Monuments In Uighur - Mongolian Scripts” (XIII-XVI Centuries) Taipei, Taiwan, 2006., 19-р тал.

⁷ Мөн номын 22-р тал.

⁸ “Word - and Suffix-index to Hua-yi Yi-yü” compiled by Hitoshi Kuribayashi, Tohoku University, Sendai, 2003., 68-р тал.

⁹ Mongolian Monuments in ‘Phags-pa Script, Edited by D. Tumurtogoo with the Collaboration of G. Cecegdari, Institute of Linguistics, Academia Sinica, Taipei, Taiwan, 2010. 108-р тал.

¹⁰ Louis Ligeti “le subhâsitaratnanidhi mongol” Budapest, 1948., 42-р тал.

Зая Бандид Намхайжамцын орчуулга (XVI-XVII зуун)

jibxulang ori ülü ködölkü
Tөгүнчилen yeke boqdo **batu**
Moduni ungyaral үсүүken-dü ködölkü metü
Doroduši-yin yabudal urbaxu körböкү yeke

Мэргэн гэгээн Дамбажалцаны орчуулга (XVIII зуун)

sümbür inü kerkibeçü ülü ködelemüi y-e.
tegünчилen degedüs-ün sedkil inü **batu bui.**
Modun daki ungyaril-ud kilbar-iyar ködelüm
Tөгүнчилen dooradus-ud urbal körbe. yeke bui.

Төгөлдөрийн Галсанжинбын орчуулга (XVIII зуун)

sümbür inü kerkibeçü ülü ködülemüi y-a.
tegünчилen degdüs-ün sedkil inü **batu bui.**
Köbüng inü өсүгүken salkin-iyar ködelüm
Tөгүнчилen dooradus-ud urbal körbel yeke bui.

Цахар гэвш Лувсанцүлтэмийн орчуулга (XVIII зуун)

üjeskүlengtü sүmir аyула yerü ülü күdelkү metü
ünen sayin činar-tu күmүн **kejiyede тоytaуun yabuqu**
өсүken күbүng-үн keseg тоytaуuri ügei keyiskү metü
ötele mayu күmүн basa basa qubiluysayar байiqu

Сумадирадна (Номтын Ринчэн)-гийн орчуулга (XIX-XX зуун)

jibqulang-tu Sümer аyула yerü ülü ködelkü
jibqulang-tu yeke бойdas **töbsin batu**
jibar өсүken-iyer modun-u ungyaril ködelkü metü
jigsikүi-tү dooradus-un yabudal-un urbal körbel yeke bolai

“Субашид” Соном Гарагийн орчуулгад “čing” хэмээх үг энд эш татан харьцуулснаас гадна 2 удаа тохиолдож байна. Үүнд:

བརྩོན་འགུས་ཅེ་ཞིང་བརྟན་ལ་གྲིམ།
བརྩན་གཡོག་ཡིན་ཡང་དབོན་ཏུ་འགྲུང།

“yekede kičigen čing bisayun bolbasu boyul taqi bolbasu noyan boluyu tere”¹¹ (Ихэд хичээн чин бишуу(бушуу) болбоос Боол тахи(мөн, бас) болбоос ноён больюу, тэр)

རྟན་ཏུ་འབྱེད་ལ་བརྩོན་པའི་མིས།
མཇེ་བ་བརྟན་པོ་འང་བྱེད་འགྲུང་།

“qayačayulquy-anasu kičiyegči күmүн čingamarakduysad-iber qayačayuluу”¹² (хагацуулахуйяа нас хичээгч хүн чин амралдагсдыг бээр хагацуулыюу)

Дээрх хоёр жишээнд мөн л төвд хэлний “བརྟན” (brtan) хэмээх үгийг “čing” хэмээн орчуулжээ. Эхний жишээнд, төвд хэлний “གྲིམ” (grim) хэмээх “шамдах” гэсэн утгатай үгийг “bisayun

¹¹ Louis Ligeti “le subhâsitaratnanidhi mongol” Budapest, 1948., 13-р тал.


¹² Мөн номын 52-р тал.

bolbasu” гэж орчуулжээ. Төвд эхийн “བརྟན་ལ་གྲིམ” (brtan-la-grim) нь “бат төвшинийг шамдваас” гэсэн утгатай болно. Ямар боловч, “Субашид”-ын XIII-XIV зууны орчуулгын баримт нь “cing” хэмээхийг “бат бэх” гэсэн утгаар хэрэглэж байсныг харуулав.

Эдгээр баримтаас үзвэл, төвдийн “brtan” хэмээх үгийг эрт цагтаа “cing” хэмээн орчуулдаг байсан бол хожим “бат, төвшин, тогтуун” гэх мэт үгээр орчуулах болжээ. Энэхүү орчуулгын харьцуулалаас “cing” хэмээх үгийг “Цагаан түүх”-ийн энэ эхэд “бат бэх”, “тогтуун төвшин” хэмээсэн утгаар хэрэглэснийг мэдэж болно. Монгол хэлний “чин”(cing) хэмээх үг “cingy-a” (чанга), “cingda”(чанд), “cingdalaqu”(чандлах) гэх мэт үгийн язгуурт тохиолдоно.

“Цагаан түүх”-ийн дээр эш татсан хэсгийг тодруулан ухаарах хэмээвээс “энх чин” хоёрын утга учрыг сайн мэдэх ёстой. Тэгвэл, “ертөнцийн төрх энх чин хоёр” хэмээн юуг өгүүлдэг болохыг “Цагаан түүх”-д хэрхэн тайлбарласныг үзье:

7а тал



“...erten-ü boydas-un bayiyuluysan quuli üliger-ün yosuyar, amitan-a tusatu sayin ügesi[=üges-i] soyun suryaju бүрүн, engke törü-ber γar γajara[=γajar-a] köl kösere[=köser-e] amurliyulbasu ulusi[=ulus-i] jasyči jarliy-un sitügen qonjin kemeyü. yeke törü cing bolqui čay-un yosun-i[=yosun-u] serel manjil yeke ulus-tur dyyulyaju бүрүн, qari dayisun-i ary-a kücün-iyer daruyulun čidabasu irgen oryun-i sakiyči jirüken-i[=jirüken-ü] sitügen qonjin kemeyü...”

(Амьтнаа туст сайн үгсийг соён сургаж бүрүүн, энх төрөөр гар газраа, хөл хөсрөө амарлиулбаас улсыг засагч зарлигийн шүтээн хонжин хэмээюү. Их төр чин болохуй цагийн ёсны сэрэл манжил[-ыг] их улсад дуулгаж бүрүүн, харь дайсныг арга хүчээр даруулан чадваас иргэн оргоныг сахигч зүрхний шүтээн хонжин хэмээюү...). Энэ хэсгээс үзвэл, хааны барих төр ёс буюу энх төр нь бүх нийтийг сурган соёж, гар газраа, хөл хөсрөө амарлиулж, улсыг засах үүрэгтэй ажээ. Харин түшмэлийн барих төр буюу чин төр нь цагийн байдлыг сэрэн болгоож, харь дайснаас сэрэмжилж, ард иргэнийг сахин хамгаалах үүрэгтэй ажээ. Энэ хэсэгт гарсан “serel manjil” хэмээх үгийг судлаачид “saral manjil” хэмээн уншиж, ямар утгатай болохыг тааварлан бичдэг.

“Бадамжунайн намтар”-ын Сажа Дондовын орчуулга 192а тал




“Бадамжунайн намтар”-ын Сажа Дондовын орчуулга(XVI зууны эцэс үеийн)-д энэ үг гарч буй. “Цагаан түүх”-д бодтой нөлөө үзүүлсэн “Дисрондивзан хааны цааз”-ын зүйлийг өгүүлсэн хэсэгт “dayin[=dayin-i] seren manjiju, uruγ-luγaban amaralduytun” (192a) хэмээжээ.

Сажа Дондовын энэ орчуулгыг, төвд эхтэй нь тулгавал, $\text{ᠳᠠᠭᠠᠨ ᠲᠡᠭᠦᠬᠡ ᠰᠡᠷᠡᠮᠵᠢᠵᠢ ᠰᠡᠷᠡᠮᠵᠢᠵᠢ ᠰᠡᠷᠡᠮᠵᠢᠵᠢ}$ *dgra-la-zon-chug-gnyen-la-nang-gshin-gyis* гэж буй. Төвд эхийн ᠵᠠᠭᠠᠨ ᠲᠡᠭᠦᠬᠡ (*zon-chug*) хэмээхийг “seren manjiju” хэмээн орчуулсан тул утга нь тодорхой болов. Төвд өгүүлбэрийг орчуулбал “*Дайсныг сэрэмжлэн болгоомжилж, ураг садан дотроо эв зетэй байгтун*” хэмээжээ. Төвд хэлний ᠵᠠᠭᠠᠨ ᠲᠡᠭᠦᠬᠡ (*zon-chug*) хэмээх үгийг “сэрэмжтэй болгох”, “сэрэмжийг базаах”, “сэрэмжлэн болгоомжлох”, сэрэмжийг банжих гэж орчуулна. Харин монгол хэлний “manjiqu” хэмээх үг одоо мартагдаж, түүний авиа сэлгэсэн(m~b) хэлбэр “banjiqu”(банжих) нь “зэхэж бэлдэх”, “бэлэн байлгах” гэсэн утгаар хэрэглэгдэж буй. Тус үгийн энэ хэлбэрээс “-n”(н) гийгүүлэгч авиа нь сугарч “bajayaqu”(базаах) хэмээсэн үгийн хэлбэр буй болсоныг Сэцэнцогт “Монгол үгсийн язгуурын толь”-доо тодорхой заасан буй.¹³ Энэ мэт тодруулга хийвэл “*yeke törü čing bolqui čay-un yosun-i[=yosun-u] serel manjil ...*” (их төр чин болохуй цагийн ёсны сэрэл манжил...) хэмээх нь “их төр бат төвшин болоход цагийн байдлын сэрэмж болгоомж[-ийг]” гэсэн утгатай болж, бүхэл өгүүлбэр зөв ухагдах буй.

“Сэрэл манжил”-ын тухай тайлбараа үүгээр төгсгөж, “cing” хэмээх үг “Цагаан түүх”-ийн өөр хэсэгт хэрхэн орсныг авч үзье.

¹³ Sečenčoytu “mongyol üges-ün ijaγur-un toli” köke qota, 1988.

56 талд

“edüge bi tegünčilen qoyar yosun-i tegsi-ber yabuγulsuyai kemeged, tegüber eng terigün qoyar yosun ali kemebesü, nom-un törü tarni sudur kiged yirtinčü[-yin törü] **engke čing qoyar yosun-ača angq-a urida nom-un yosun-i ekilejü yabuγuluγčin kemebesü**”(Өдгөө би түүнчлэн хоёр ёсныг тэгшээр эн тэргүүн хоёр ёс аль хэмээвээс, номын төр тарни судар хийгээд ертөнц[-ийн төр] **энх чин хоёр** ёсноос, анх урьд номын ёсныг эхэлж явуулагчин хэмээвээс)


Гандан хийдэд байсан эхээс бусад эхүүдэд “čing”(чин) хэмээх үгийг “engke kilbar(~gilber)” гэж буй.

6а талд

“γurban čay-un burqan, γurban yeke gūisiri mürgül-ün γučin qoyar burqad,[+ čiyuluysan naiman bodisung, arban jiryuyan čing oruda, γučin qoyar sonusun sakičid, taban jayun toy-a-tu dörben jüil quwaray, dörben ...” (гурван цагийн бурхан, гурван их гүүшри, мөргөлийн гучин хоёр бурхад, чуулсан найман бодисун, арван зургаан чин ород, гучин хоёр сонсон сахигчид, таван зуун тоот дөрвөн зүйл хувраг, дөрвөн ...)

16 архадыг төвдөөр གནས་བརྟན (gnas-brtan) гэдэг. Хуучин орчуулгад санскритаар нь “arqad” (санс. arahanta) хэмээх буюу “batuda aγci” хэмээн орчуулсан байдаг. Харин “Цагаан түүх”-д “čing oruda” хэмээсэн нь тун эртний орчуулга бололтой. “čing” нь төвдийн “བརྟན” буюу “бат” болно. Төвд хэлний “གནས” (gnas) орон, орших гэсэн утгатай. “Цагаан түүх”-д “орон” гэсэн утгаар орчуулж, «-tan» дагаврын нэг шүд гэсэн ташаа хэлбэрийг залгасан бололтой. Харин арай хожмын орчуулгад “aγci”(агч) хэмээн тохиолдох нь “оршигч” гэсэн утгаар нь хэрэглэсэн болно. Эдгээрээс үзвэл, “čing” хэмээх үг нь “batu”(бат) хэмээсэн утгатай болохыг бас баталж буй хэрэг.

76 талд



“dörben yeke törü inü ali bui kemebesü, nigedüger yeke kölgen-ü yosun amuyulung törü, qoyadyar niyuča kölgen-ü yosun jiq-a üne[=ünen] törü, γudyar qayan-u bariγci čing törü kiged buyu: ...” (Дөрвөн их төр нь аль буй хэмээвээс, нэгдүгээр их хөлгөний ёс амгалан төр, хоёрдугаар нууц хөлгөний ёс зах үнэн төр, гуравдугаар хааны баригч энх, дөрөвдүгээр түшмэдийн баригч чин төр хийгээд буюу)

Энэ хэсэгт гарах “čing”(чин) хэмээх үгийг Гандан хийдэд байсан эхээс бусдад “dayičing” гэж буй. Энэ нь хожмын хувилбаруудад орсон сүүл үеийн үг болно.

Шинээр олсон “Цагаан түүх”-ийн эхэд “čing” гэдэг үг тогтвортой нэг хэлбэрээр тохиолдох бөгөөд “бат” хэмээсэн нэг л утгаар хэрэглэжээ.

Төгсгөлд тэмдэглэхэд, шинээр олсон “цагаан түүх”-ийн эх маань, “Цагаан түүх”-ийн эх бичгийн судалгаанд зохих тус хүргэх судар тул харьцуулан судалж, судлаачдын хүртээл болгохыг зорьж байна.